

Төслийн мэдээлэл 2011 оны 8 дугаар сар №2

Хичээлийн судалгааны хэрэгжилтийн тайлан

Хичээлийн судалгаа

Энэхүү төслөөр “Хичээлийн судалгаа” хэмээх арга зүйг ашиглан, багшийн арга зүйг шинэчлэхээр зорьж байна. Хичээлийн судалгаа нь, 1) Хичээлийн бэлтгэл (Хичээлийн бэлтгэл судалгаа), 2) Хичээл явуулах (Судалгаат хичээл) болон бусад багш нар ажиглалт хийх, 3) Хичээлтэй холбоотой хэлэлцүүлэг гэсэн 3 алхамтай. Хичээл заах багш хичээлд ажиглалт хийсэн бусад багш нараас зөвлөгөө авч, арга зүйгээ сайжруулах боломжтой болно. Мөн, ажиглалт хийх багш нар ч, хичээл явуулах багшийн шинэлэг арга зүй, шалгарсан арга зүйгээс суралцах боломжтой.

Энэхүү хичээлийн судалгааг Японд 100 гаруй жилийн өмнөөс хийж эхэлсэн бөгөөд дэлхийн нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байгаа билээ. Монгол Улсын БСШУЯ хичээлийн судалгааны чухал ач холбогдол өгч, “2010-2011 оны хичээлийн жилийн зорилт”-доо “ЕБС-ийн бүх багш нар хичээлийн судалгааг хэрэгжүүлэх аргачлал, өөрөөр хэлбэл шинэ арга зүйг судлахын зэрэгцээ бүх сургуулиуд хичээлийн судалгаа хийх төлөвлөгөө боловсруулан, энэ хичээлийн жилд 2-оос доошгүй удаа хичээлийн судалгаа хийх” гэж тусгажээ.

Загвар сургуулиуд дахь хичээлийн судалгааны хэрэгжилт

Төслийн загвар сургуулиуд 2011 оны 2-3 сард хичээлийн судалгааг зохин байгуулсан.

Мэргэжлийн баг болон төслийн багийн зүгээс 1) 2010 оны 11 сард төслөөс зохион байгуулсан сургалтын үр дүн болон тулгамдсан асуудлыг тодорхойлох, 2) Бүх загвар сургуулиудын хичээлийн судалгаанд зөвлөгөө өгөх зорилгоор мониторинг хийсэн.

“Төслийн мэдээлэл №2”-т, бүх загвар сургуулиудад зохион байгуулагдсан хичээлийн судалгааны явц болон загвар сургуулиудын сэтгэгдлийг толилуулж байна.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргээс Ирээдүй цогцолбор сургууль, 12-р сургууль, 67-р сургуулиуд тус төслийн загвар сургууль болсон юм.

Ирээдүй цогцолбор сургуулийн 3-р бага сургуулийн төсөлт ажлын хичээлээр, сурагчид өөрсдөө “Ус” хэмээх сэдвийг сонгон авч, уг сэдэвт тохирсон асуудлуудын талаар баг бүр судалгаа хийжээ. Судалгаат хичээл явуулсан явцын тайлангаас, сурагчид “Орон сууцны болон гэр хороолол дахь усны ашиглалтыг харьцуулсан судалгаа” зэрэг сонирхолтой танилцуулгыг хийж, судалгааныхаа явцад багш сайын зөвлөгчийн үүрэг гүйцэтгэж тухай дурьдсан байсан.

67-р сургуулийн химийн судалгаат хичээлээр туршилт явуулж, сурагчдын ажиглалт хийх чадвар, хичээлийн сонирхол, оролцоо дээшилж байгааг тогтоосон. Өнөөг хүртэл хичээлд сорил туршилт явуулах боломж хомс байсны улмаас туршилт хийхэд хүндрэлүүд гарч байлаа. Энэ удаагийн судалгаат хичээл, хичээлийн хэлэлцүүлгээр дамжуулан “Хичээлээр юуг хүүхдүүдэд ойлгуулах”, “Хүүхдийн хариултыг урьдчилан тооцох” нь сурагчдын идэвхитэй үйл ажиллагаанд дэмжлэг болдог болохыг ойлгосон байна.



Математикийн судалгаат хичээлийн явц
(Сэлэнгэ сумын сургууль)

“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

Монгол Улсын боловсролын салбарт 2005 оноос цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлж эхлэсэн билээ. Энэхүү шинэ стандартаар, сурагчдын өөрсдөө мэдлэг бүтээх чадварыг хөгжүүлэх, улмаар багш бүр сургалтын шинэ арга зүйг эзэмших явдал зайлшгүй чухлаар тавигдана.

Иймд, БСШУЯ болон ЖАЙКА хамтран 2010 оны 4 сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)” төслийн хүрээнд боловсруулсан багшид зориулсан зөвлөмж, эдүгээ боловсруулж буй сургалтын модулийг ашиглан суралцахуйд суурилсан багшлах арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүтэц, тогтолцоог бэхжүүлэх явдал юм.

Тус төслийг МУИС, МУБИС, Боловсролын хүрээлэн болон өмнөх төслийн холбогдох хүмүүсээс бүрдсэн “Мэргэжлийн баг” загвар аймаг, дүүрэг болох Сонгинохайрхан дүүрэг, Булган аймаг, Завхан аймагтай хамтран хэрэгжүүлж байна.

Гарчиг:

Хичээлийн судалгааны хэрэгжилтийн тайлан	1-2
“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”	1
Хичээлийн судалгаа хэрэгжүүлэх сургалт семинар зохион байгуулав	2
Төслийн зөвлөх багш нарын өгсөн зөвлөмж	3
Цаашдын төлөвлөгөө	4
Төслийн зохицуулагчийн танилцуулга	4
Төслийн багийн талархал	4
Төслийн багийн холбоо барих хаяг	4

Булган аймаг

Булган аймагт 1-р сургууль, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Гурванбулаг сумын сургууль зэрэг нийт 5 сургууль загвар сургуулиар ажиллаж байна.

Хишиг-Өндөр сумын сургуулийн “Хүн байгаль” судалгаат хичээлд мөн сорил туршилт зохион байгуулсан. Ажиглалтаар дамжуулан дүгнэлт гаргахад хүүхдүүдийг сургахаар зорьсон. Туршилтын хэрэглэгдэхүүн дутмаг байгаа ч, гарын доорхи материалаар туршилтын хэрэглэгдэхүүн хийх зэргээр санаачлага гарган ажиллаж байна. Энэ удаагийн хичээлийн судалгаагаар дамжуулан аюулгүй ажиллагааг хангахын чухлыг ойлгож авчээ.

Завхан аймаг

Завхан аймагт Чандмань Эрдэнэ цогцолбор сургууль, Тосонцэнгэл, Сонгино, Баянтэс, Завханмандал, Шилүүстэй сумын сургууль зэрэг нийт 6 сургууль загвар сургуулиар ажиллаж байна.

Сонгино сумын сургуулийн “Хүн орчин” судалгаат хичээлээр сурагчдын өмнөх ойголт мэдлэгт тулгуурлан хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн. Энэ удаагийн туршлагаас, хичээлдээ сайтар бэлтгэж чадвал, хичээл үр дүнтэй болохыг ойлгож авсан. Хичээлийн судалгаа нь багш нар, багш сурагчид, тэрчлэн сурагчид бие биенээсээ суралцах боломжийг буй болгодог. Хичээлийн судалгаанд оролцсон багш нар өөрсдийнхөө арга зүйг сайжруулах чин эрмэлзэлтэй болжээ.

Шилүүстэй сумын сургуулийн “Мэдээлэл зүй” судалгаат хичээлээр, өдөр тутам идэвхи султай сурагчид ч хичээлд идэвхитэй оролцож байгаа нь ажиглагдсан. Өнөөг хүртэл зохион байгуулж ирсэн нээлттэй хичээлээр багш бүгдийг ганцаараа хийдэг

байсан. Харин хичээлийн судалгаанд олон багш нар хамтран хичээлд бэлтгэдэг. Мэдээлэл зүйн хичээлийг явуулсан багш “Хичээлийн бэлтгэлээр дамжуулан, туршлагатай багш нараас суралцсан” гэж дурсжээ. Мэдээж, хичээл тэр чигээрээ төлөвлөгдсөний дагуу явагдаж чадаагүй. Гэхдээ цаашдын хичээлүүдийг улам сайжруулахад туршлага болох үүднээсээ энэ удаагийн хичээл нь туйлын ач холбогдолтой болсон байна.

Хичээлийн судалгааны үр дүн ба тулгамдсан асуудал

Энэ удаагийн хичээлийн судалгаагаар дамжуулан, ихэнхи загвар сургуулиуд дараахи үр дүд хүрсэн хэмээн тайлагнажээ.

- Хичээлийн бэлтгэл чухал болохыг ойлгож эхэлсэн.
- Багш нар хамтран хичээлээ бэлтгэж, харилцан бие биендээ зөвлөснөөр их зүйлийг сурч мэдсэн.
- Хүүхдүүдийн өмнөх мэдлэгт тулгуурлан хичээлээ бэлтгэх, хүүхдийн хандлагыг тооцохын чухлыг ойлгосон.
- Багшийн арга зүй өөрчлөгдсөнөөр хүүхдүүдэд ч өөрчлөлт ажиглагдаж байна. (Хичээлд идэвхитэй оролцон, багаар ажиллах чадвар дээшилсэн зэрэг)

Нөгөө талаар дараахи хүндрэлүүд ч гарч байна.

- Хичээлийн бэлтгэлд цаг хугацаа их шаардаж байна.
- Ижил мэргэжлийн багш нар цөөн тул мэргэжлийн зөвлөгөө авахад хүндрэлтэй.
- Туршилтын хэрэглэгдэхүүн дутмаг.

Бүх сургуулиуд гарын доорхи материалаар туршилтын хэрэглэгдэхүүн хийх зэргээр янз бүрийн санаачлага гарган, хүндрэлийг даван туулж байсан. Мөн, сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн идэвхитэй хамтын ажиллагаа хичээлийн судалгаанд зайлшгүй чухал байлаа.



Баянтэс сумын сургуулийн захирлын танилцуулга



Багын математикийн багийн ажил



Төслийн зөвлөх багшийн лекц

Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх сургалт семинарыг зохион байгуулагдлаа

2011 оны 6 сарын 2-4-нд, загвар аймаг, дүүргийн холбогдох хүмүүс, мэргэжлийн багийн гишүүд зэрэг 100 гаруй багш нар цуглан, хичээлийн судалгааг хэрэгжүүлэх сургалт семинарыг зохион байгууллаа.

Семинарын эхний өдөр, бүх аймаг, дүүрэг дэх багшлахуйн арга зүйн шинэчлэлийн талаар танилцуулга хийгдэж, хичээлийн судалгааг хэрэгжүүлснээр багш сурагчдад гарч буй эерэг өөрчлөлт, цаашдын тулгамдсан асуудлуудын талаар санал бодлоо солилцов. 2 дахь өдөр, төсөлд 1-р шатнаас эхлэн оролцож байсан багш нар судалгаат хичээл зохион байгуулж, оролцогчид саналаа идэвхитэй солилцсон. Сүүлийн өдөр, төслийн зөвлөх багш нар “Бага дунд боловсрол дахь хичээлийн судалгааны ялгаа”, “Хүүхдийн суралцах чадварыг хэмжилт хийх аргаар илрүүлэх нь” сэдвээр лекц уншсаны дараа, загвар аймаг дүүргүүд 2011-2012 оны хичээлийн жилд багшлахуйн арга зүйгээ шинэчлэх төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулсан.

Семинарт оролцогчдын илтгэлүүдэд, хичээлийн судалгааг хийснээр багш төдийгүй сурагчдад ч өөрчлөлт гарч буйг анзаарч эхэлж буй тухай дурьдагдаж байлаа. “Хүүхэд хичээлдээ сонирхолтой болсон”, “Өөрийн санаа бодлоо илэрхийлж чаддаг болсон” гэх зэргээр саналаа хэлж бйасан юм.

Түүнчлэн, уг семинарт Улаанбаатар хот, Булган аймаг, Завхан аймгийн төслийн холбогдох хүмүүс анх удаа нэг дор цуглан уулзацгаасан юм. Тус тусын олсон ололт амжилт, туршлага, гарч буй хүндрэлүүдийн талаар ярилцсан нь багш нар өөр хоорондоо дэм өгөх сайхан боломж болжээ.

Хичээлийн судалгаанд төслийн зөвлөх багш нараас өгсөн зөвлөмж

Хичээлийн судалгааны ач холбогдолыг улам бүр дээшлүүлэх зорилгоор төслийн зөвлөх багш нарын хэд хэдэн зөвлөмжийг толилуулж байна.

1. Хичээлийн судалгаанд нийцэхүйц хичээл

Хөндлөнгийн ажиглагч оролцуулсан судалгаат хичээлээр ажиглагч дараахи зүйлүүдийг сурч мэдэхүйц судалгаат хичээлийг явуулах шаардлагатай.

- Хичээлийг удирдан явуулахад олон арга байж болохыг анзаарч ойлгох.
- Хүүхдийн чадвар хөгжиж буйг анзаарч мэдэх.
- Хичээлд ямар хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой болох талаар ойлголтоо гүнзгийрүүлэх.
- Хүүхдийн бодол санааг олж харах чадвар дээшлэх.

Дээрхи зүйлүүдийг суралцах боломжтой хичээл гэдэг нь, шинэлэг ойлголт, шинэлэг бодол санаа, шинэлэг үзэгдлийг тусгасан хичээл, хүүхдүүдийн сэтгэн бодох чадварыг дээшлүүлэн асуудлыг шийдвэрлэх хичээл, хүүхэд болон багш, хүүхдүүд хоорондын харилцаанаас хүүхэд өсөж хөгжиж байгаа нь харагдахуйц хичээл юм.

Өөрөөр хэлбэл, ердийн хичээлийг дахин давтан орох, зүгээр л тоо бодон дасгал ажиллах, шалгалт авах, ном унших төдийхний хичээлийг судалгаат хичээл гэж үзэх боломжгүй. Хичээлийн судалгаа хийх өдөр иймэрхүү хичээл таарсан тохиолдолд, хөтөлбөртөө зохицуулалт хийх шаардлагатай.

2. Судалгаат хичээлийн суралцагч

Багш болж өгвөл өөрөө өдөр тутам хичээл заан, түвшин, чадвар, зан төлөвийг нь сайтар мэддэг хүүхдүүдэд хичээл заавал зохино. Энэ нь хүүхдүүдийг хичээлд бүрэн хамруулж, бүгдийг нь хөгжүүлэхийн тулд хичээлийн явцад хүүхэд тус бүрийн түвшин, чадвар, зан төлөвт тохирсон асуулт тавьж, илтгэл тавиулах шаардлагатай байдгаас тэр юм.

3. Хичээлийн хөтөлбөр

Хичээлийн бэлтгэл бол туйлийн чухал хичээлийн судалгааны процесс юм. Хичээл төлөвлөхдөө хичээлийн сэдвээ сайтар базах нь чухал. Жишээ нь, байгалийн ухааны ээлжит хичээлээр 3-4 туршилт хийх боломжгүй.

Хичээлийн хөтөлбөрт, хүүхдийг ажиглахтай (өөрөөр хэлбэл, хүүхдийн өдөр тутмын туршлага, хэдийн суралцсан зүйл, өмнөх хичээлийн агуулга) холбоотой тайлбар шаардлагатай болно. Тухайн цагийн хичээлээр “Ямар байсан хүүхэд (Хичээл эхлэхийн өмнөх хүүхдийн төлөв)”-ийг “Ямар хүүхэд (Хичээлийн дараахи хүүхдийн төлөв)” болгон өөрчлөхөө тодорхой тусгах нь зүйтэй.

4. Хичээл явуулах

1) Мэдээллийн хэрэгсэл ашиглах:

Энгийн хичээлд проектор ашигладаггүй байснаа зөвхөн судалгаат хичээлийн үеэр хүчээр ашигладаг гэх мэт асуудал байгаа болов уу? Мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа, түүнийг хичээлд ашиглах зайлшгүй хэрэгцээ бий эсэхийг сайтар нягтлах шаардлагатай.

2) Самбар ашиглалт

Японы бага сургуулиудад, ээлжит хичээлийн явцад багш дахин дахин самбарт юм бичиж арчаад байдаггүй.

Самбарт бичигдсэн зүйлийг хүүхдүүд дэвтэртээ буулгахад, дэвтрээсээ тухайн цагт үзсэн зүйлээ мэдэж болохуйцаар төлөвлөн бичигдсэн байдгаас тэр юм.

Хичээлийн судалгаанд самбар ашиглалт туйлийн чухлаар тавигдана. Ажиглагч тухайн самбарын бичиглэлийг хараад, багшийн санааг олж мэдэх боломжтой. Нөгөө талаар, хичээл зааж буй багшийн хувьд ч урьдчилан самбар ашиглалтаа төлөвлөснөөр өөрийнх нь хичээлийн төлөвлөгөө тодорхой бөгөөд ойлгомжтой болж, юуг сайжруулах шаардлагатайгаа олж харахад хялбар болно.

3) Хүүхдийг урамшуулах

Хичээлийн явцад хүүхдүүдийг урамшуулж буй хичээл ч байдаг бололтой. Энэ нь хүүхдийн сурах хүсэл сонирхолыг дээшлүүлэх аргынхаа хувьд үнэхээр тохиромжтой арга мөн үү? Өөрөөр хүүхдийн сурч мэдэх хүслийг дээшлүүлэх арга байх л ёстой. Ердийн үед сурагчдаа ажиглаж байвал, ямар үед юуг нь магтаад өгвөл үр дүнтэй болохыг ойлгоно.

4) Цаг хуваарилалт

Хичээлийг цагтаа багтаан дуусгах нь үндсэн зарчим хэдий ч, төлөвлөснийхөө дагуу хичээлээ явуулах гэж хэт хичээх нь “Хүүхэд төвтэй” багшлах арга зүйд тэр бүр нийцэх муутай. Тухайн нөхцөлд хүүхдийнхээ төлөв байдлыг ажиглан, түүнд нь тохируулан цаг хуваарилалтаа өөрчилж чадаж байваас сая “Хүүхэд төвтэй” болно.

5. Хичээлийн ажиглалт

1) Ажиглагчийн үүрэг

Хичээлийн ажиглалтыг хийхдээ, болж өгнвөл ажиглагчийн үүргийг ангилахгүй байх нь дээр. Зөвхөн нэг л зүйлийг ажиглах бус, хичээлийн ерөнхий явцыг харах хэрэгтэй. Хичээлийн ерөнхий явцыг ажигласнаар хичээл сайн муу болсныг мэдэж авахын зэрэгцээ ажиглагч өөрөө шинэ зүйл сурч мэдэх боломжтой болно.

Тодорхой нэг хүүхдийг анхааран ажиглахдаа зорилгоо тодорхой болгох.

2) Ажиглалтын харалт

Багш хичээлийн судалгааныхаа сэдвийг ажиглагч багш нарт урьдчилан хэлж, ямар зүйл дээр анхааран ажиглалт хийлгэмээр байгаагаа тодорхой болговол зүгээр. Мөн, юу юунаас илүү хүүхдийн хандлагыг анзаарах хэрэгтэй. Хүүхдүүдийн царайг харж болохуйц байрлалаас ажиглалт хийх нь гол үндэс болно.

3) Ажиглалтаар оноо өгөх тухай

Японы сургуулиудын хичээлийн судалгаанд багшид оноо өгөх маягаар багшийг үнэлдэггүй.

6. Хичээлийн хэлэлцүүлэг

Хичээлийн дараахи хэлэлцүүлгийг тухайн хичээлийг явуулсан танхимд зохион байгуулах нь хамгийн тохиромжтой. Хичээлд ашигласан самбар болон үзүүлэн, туршилтын хэрэглэгдэхүүнийг байлгахад яриа идэвхитэй өрнөж, сайжруулбал зохих зүйлүүдийг онцлон ярилцахад хялбар болно.


Япон багш нар хэр завгүй ажилладаг вэ ?

Японы бага сургуулийн багш нар 7 хоногт дунджаар 18.8 цаг, дунд сургуулийн багш нар 14.6 цагийн хичээл заадаг байна (7 хоногийн нийт ажлын цаг нь 40 цаг). Монгол багш нартай харьцуулахад, хичээлийн цаг багатай мэт санагдаж болох юм.

Багшийн ажил бол зөвхөн хичээл заах явдал биш. Хичээлийн бэлтгэл судалгаа гэх мэтээр тухайн хичээлийг заахад бэлтгэх, шалгалтын асуулт боловсруулах болон сурлагын дүнг тооцох, хүүхдүүдийг сургууль дээр байх үед хичээлээс гадуурхи үйл ажиллагаа, секц дугуйлан ажиллуулах, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээдэг. Мөн, эцэг эхийн хурал, сургуулийн арга хэмжээ, багш ажилтны хуралд оролцохоос гадна сургуулийн захиргаа, сургалтын зөвлөлд тайлан боловсруулж өгөх зэрэг янз бүрийн ажил үүргийг хүлээдэг байна.

Олонхи багш нар хурал цуглаан, тайлан бичихэд цагаа зарцуулан, бага ч атугай хүүхдүүдээ цаг зав гаргахыг эрмэлздэг байна. Монголын багш нарын хувьд ямар байдаг вэ?

Япон Улсын Боловсрол, Шинжлэх ухааны Яамны “Багш нарын статистик судалгаа”-наас (Тоо баримт нь 2010 оны 10 сарын 1-ний байдлаар)



Энэхүү төслийн мэдээллийг Монголын уншигчдад зориулав.

Цаашдын төлөвлөгөө

МУБИС-ийн багш нарт зориулсан “Хичээлийн судалгаа”-ны арга зүйг танилцуулах сургалт

Төслийн баг, БСШУЯ болон МУБИС-тай хамтран 2011 оны 8 сарын 29-30-нд МУБИС-ийн харьяа 12 дээд сургуулийн удирдлага, багш нарт зориулсан “Хичээлийн судалгаа”-ны арга зүй, сургалтын модулийг танилцуулах зорилгоор сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх сургалт

Бүх аймаг, дүүргийн БСГ/БХ болон загвар сургуулиудад зориулан, 1) Суралцахууд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны талаархи мэдлэгийг нь гүнзгийрүүлэн, 2) Арга зүйн шинэчлэл дэх удирдлага, багшийн үүрэг оролцоог тодорхойлж, 3) Хичээлийн судалгаа хийх чадварыг хөгжүүлэх зорилгоор сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.

Сургалтыг 2011 оны 11 сард, Улаанбаатар хот (2 газар) болон Булган, Завхан, Сэлэнгэ, Дорнод аймгуудад зохион байгуулна.

Багшлахуйн арга зүйн шинэчлэлийг цаашид үргэлжүүлэн хэрэгжүүлэх явдал туйлын чухал. Төслийн баг цаашид ч, мэргэжлийн багтай хамтран Монгол Улсад багшлахуйн арга зүйн шинэчлэх үйлсэд тодорхой дэмжлэг үзүүлэн ажиллах болно.

Төслийн зохицуулагчийн танилцуулга

2011 оны 6 сараас эхлэн төслийн зохицуулагчаар МУИС-ийн Хими, Хими технологийн сургуулийн багш, Мэргэжлийн дидактикийн сургалт, судалгааны төвийн захирал Н.Оюунцэцэг томилогдон ажиллаж байна.

Төслийн зохицуулагчийн мэндчилгээ:

Боловсролын салбарт олон тооны төсөл хэрэгжиж байгаа боловч, тус төсөл нь багшийн арга зүйг өөрчлөх, сургууль төвтэй багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоог буй болгоход чухал үүрэг гүйцэтгэж байгаагаараа онцлогтой. Өмнөх төслийн талаар та бүхэн хангалттай мэдээлэлтэй байгаа (8 судлагдахууны зөвлөмж боловсруулсан). Энэ удаагийн төслийн эхний жилд загвар аймаг, дүүргийн сургуулиудын удирдлага, багш нарт зориулсан хичээлийн судалгааны арга зүйн сургалтыг зохион байгуулж, энэ чиглэлээр Япон Улсад зохион байгуулдаг сургалтад мэргэжлийн багаас 8, ЖАЙКА-ийн бусад сургалтад 18 багш, мэргэжилтэн сургалтад хамрагдаж ирээд, төслийн үйл ажиллагаанд идэвхитэй хамтран ажиллаж байна. Төслийн 2 дахь жилд, нийт 38 багш, мэргэжилтэн сургалтад хамрагдахаар Япон орныг зорих гэж байна. Мөн, хичээлийн судалгааны арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх шаталсан сургалтууд энэ оны 11 сараас эхэлнэ.

Суралцахууд суурилсан багшлах арга зүйн шинэчлэлд чухал үүрэгтэй хичээлийн судалгааны аргыг хөгжүүлэх тогтолцоо бэхэжсэнээр багш нарын арга зүйн шинэчлэл шинэ шатанд гарна гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Төслийн багийн талархал

2011 оны 3 сарын 11-нд, Япон Улсад тохиолдсон Зүүн Японы их газар хөдлөлтийн дараа тус төслийн загвар сургуулиуд, түүнчлэн Монголын боловсролын салбарыг төлөөлөх олон тооны багш нар харамгүй хандив тусламж, халуун дулаан урмын үг хайрласан билээ. Энэхүү завшааныг тохиолдуулан, эдгээр бүх хүмүүст гүн талархал илэрхийлье.



Төслийн
багийн холбоо
барих хаяг:

Өрөө 119, Засгийн газрын 3-р байр,
Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
Багатойруу-44, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас/Факс: 976-11-322552

Е-мэйл хаяг: <jicacctm@gmail.com>

Вебсайт:

<http://www.jica.go.jp/project/monglian/mongolia/004/index.html>